



АРХАНГАЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 05

Эрдэнэбулган сум

Үер усны аюулаас сэрэмжлүүлэх  
ажлыг эрчимжүүлэх тухай

Архангай аймгийн хэмжээнд 2018 оны 7 сарын сүүлийн хагаст орсон усархаг аадар борооны улмаас нийт нутгаар гол, горхи, нуурын усны түвшин нэмэгдэж зарим сумдад үерийн гамшиг болсон. Цаашид ус цаг уур орчны шинжилгээний газраас ойрын өдрүүдэд усархаг бороо дахин орох төлөвтэй, 8 дугаар сард уур амьсгалын дунджаас ахиу хур тунадас орох төлөвтэй байгааг мэдээлж байгаа тул үер усны аюул, гамшгаас сэрэмжлүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт ДААЛГАХ нь:

1. Гол горхи, нуурын ай сав газар болон уулын ам, гуу жалга зэрэг үерийн урсац газар амьдарч, аялал зугаалгаар явж байгаа иргэдэд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг мэдээлэл хийх.
2. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс гаргасан багц зөвлөмжүүдийг нийт хүн амд хүргэх ажлыг зохион байгуулах
3. Үерийн бодит гамшигт нэрвэгдсэн болон нэрвэгдэж болзошгүй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган ажиллах
4. Айл өрх, аж ахуй нэгжийн үерийн улмаас бохирлогдсон хөрсний лаг шавар, бохирдол зэргийг тухай бүр хуулан авч цэвэрлэж, зайлуулах ажлыг сум, баг хорооны Засаг дарга нартай хамтран зохион байгуулах.
5. Үерт автсан айл өрх, аж ахуй нэгжийн хашаа, гэр, байшин, нийтийн эзэмшлийн гудамж талбай, нүхэн жорлон, бохир усны цооног зэрэгт мэргэжлийн байгууллагаар эцсийн халдваргүйтгэл хийлгэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх.
6. Ундны усны эх үүсвэрд хяналт тавих, хүн амын аюулгүй цэвэр ундны усаар хангах ажлыг мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.
7. Үерийн улмаас сүйдсэн, бохирдсон газар ажиллаж байгаа албан хаагчид болон иргэдийн халдвар хамгааллыг дэглэмийн байдалд хяналт тавин, заавар зөвлөгөөг өгөх. Тухайлбал гарын эрүүл ахуй, хувийн хамгаалах хувцас хэрэгслийн хэрэглээ, аюулгүй ажиллагаа, удны ус, хоол хүнсний хадгалалт гэх мэт.
8. Халдварт өвчнийг эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ авах тандалтыг тогтолцоог эрчимжүүлэх, хүн амын дунд шалтгаан нь тодорхойгүй гэнэтийн

хордлого зэргийг цаг алдалгүй шуурхай мэдээлэх, тусламж үйлчилгээг үзүүлэх, хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах.

9. Иргэдэд гэдэсний халдвар, хоолны хордлогот халдвараас сэргийлэх сургалт сурталчилгааны зөвлөмж хуудас хүргүүлэх. /Хувийн ариун цэвэр сахих гараа тогтмол савандаж угаах, ундны усыг буцалгаж хэрэглэх, гэр, байшин зэрэг дотоод орчноо бихирдлоос сэргийлэн угаалга, цэвэрлэгээндээ онцгой анхааруулах/.

Албан даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ, гарсан үр дүнгийн тайланг заалт бүрээр сар бүрийн 25-нд ЭМГ-т цахимаар ирүүлэх.

ДАРГА



Р.ГАНДИЙМАА